

БАТЛАВ:

ХУЖИРТ СУМЫН

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ХҮҮХДИЙН ХООЛНЫ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛ ХҮНСНИЙ
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

**Төслийн нэр: 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР**

Төслийн дугаар: №ӨВАХУСЗДТГ/202001003/02

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Хужирт сумын Засаг даргын Тамгын Газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Өвөрхангай аймгийн Хужирт сумын хоол, хүнсний материал нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийн авна уу.

Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендерт оролцогч нь дараах санхүүгийн болон туршлагын шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байх.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан илүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

Туршлага: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын алв нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх.

Үнийн саналыг **2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутаас** өмнө хаягаар ирүүлэх ба үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

1. **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем: www.tender.gov.mn**
2. **Өвөрхангай аймгийн Хужирт сумын Засаг даргын Тамгын газар**
Үнэлгээний хороо №12 өрөө ба харилцах, утас:90112272

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /2018, 2019 оны санхүүгийн баталгаажсан тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар / болон бусад баримт бичиг;
(г) Дэлгүүрийн тохирлын гэрчилгээний хуулбар
(д) 2018, 2019 оны жилийн эцсийн татвар төлсөн баримт |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана.
Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт /ААНэгж/; Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан, акт/;</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн байдал. /Тендерийн нээлт хийх өдрийн байдлаар захиалагч татварын байгууллагаас цахим лавлагаа авна./ • Захиалагч татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. • Борлуулалтын орлого сүүлийн 2 жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. • Бусад нэмэлт шаардлага: Харилцагч банкнуудын тодорхойлолт, Шүүх, ШШГ Албаны тодорхойлолт, Татвар www.etax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт байх бөгөөд дээрх байгууллагуудаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. • ААНэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээний хуулбар нотариатаар баталгаажуулан ирүүлэх • Хугацаа дууссан бүтээгдэхүүн, чанарын шаардлага хангахгүй /норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд хэрэглэгчийг хохиролгүй болгоно гэсэн баталгааг албан бичгээр ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p>Тендерт оролцогч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 2. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Хужирт сумын ЗДТГазар Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 15 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын Хурлын танхим, Утас: 90112272 Огноо: 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 15 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.1	<p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Багц 1: Гурил, гурилан бүтээгдэхүүн 4.326.800 төгрөг Багц 2: Сүү, сүүн бүтээгдэхүүн 11.860.500 төгрөг Багц 3: Хүнсний ногоо 5.605.000 төгрөг Багц 4: Мах, махан бүтээгдэхүүн 18.087.500 төгрөг Багц 5: Бусад бүтээгдэхүүн 7.145.200 төгрөг</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Хүнсний бүтээгдэхүүн
2. **Стандарт:** Хүнсний бүтээгдэхүүн хугацаа дуусаагүй ,баглаа боодол задраагүй, хадгалалтын горим алдагдаагүй байна.
3. **Баглаа, боодол:** Үйлдвэрлэгчийн баглаа боодол хөндөгдөөгүй, тухайн бүтээгдэхүүний жин баталгаатай байна.

1. **Бараа хүргэх газар:** Хужирт сум Эрүүл мэндийнтөв
2. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагад тавигдах шаардлага:
 - Бараа, бүтээгдэхүүн нь гарал үүслийн болон лабораторийн бичигтэй байх
 - Бараа бүтээгдэхүүнийг өдөр тутам нийлүүлэх боломжтой байх
 - Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэйбайх
 - Хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй /норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хэрэглэгчийг хохиролгүй болгоно.
 - Тухайн сарын хэрэгцээнээс шалтгаалан сарын төсвөөс хэтрэх тохиолдол гардаг учраас шаардлагатай хэрэгцээгээр тасралтгүй хангаж байх
 - Баталгаат жин хэмжүүртэй байх /мэргэжлийн байгууллагын дүгнэлт бүхий/
 - Олгохоор зөвшөөрсөн дээрх нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барааны жагсаалтад орсон хүнсний бүтээгдэхүүнд дотоодын давуу эрх тооцох тул тусад нь жагсаалтаар тооцож ирүүлэх
 - Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэрэг улирлын чанартай үнэ нь хэлбэлздэг бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт хэлбэлзэлийг заавал тусгасан байх

2. Нийлүүлэх бүтээгдэхүүн нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэнбайна.

1	2	3	4	5
Д/Д	Нэр төрөл	Тоо ширхэг болон эд анги	Хэмжих нэгж	Тавигдах шаардлага
Багц 1: Гурил, Гурилан бүтээгдэхүүн				
1	Нэгдүгээр гурил 25 кг	1375	кг	Барааны нэр: Будааны төрөл /цагаан, гурвалжин, шар, хүүхдийн будаа, хүнсний хивэг, овъёос/ 1.ММ30244:2009 техникийн шаардлага хангасан байна. 2.Слава буюу орос улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц 3.Гадны механик хольцгүй, бяцарч хуваагдаагүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна. 4.Савлалт 650 гр-50 кг байна. Барааны нэр: Гоймон 1.Орос улс болон Алтан тариа үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн Барааны нэр: Гурил.
2	Дээд гурил кг	50	кг	
3	Цагаан будаа /25кг/	500	кг	
4	Гурвалжин будаа /650 гр/	62.5	10кг	
5	Шар будаа /650 гр/	50	кг	
6	Овъёос /650 гр/	80	уут	
7	Хүүхдийн будаа /1кг/	50	ш	
8	Гоймон / 3 кг /	50	кг	
9	Гоймон /5кг/	70		

10	Хөц будаа /650 гр/	50	ш	1.Гадны үнэр, амтгүй, хортон шавьж ,өндөг, авгалдай илрэх ёсгүй 2.Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ 3. Улаанбаатар, Алтан тариа үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц
11	Хүнсний хивэг /650 гр/	50	ш	
Багц 2: Сүү, Сүүн бүтээгдэхүүн				
1	Шингэн сүү	2200	л	Ерөнхий зүйл: 1. Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан, лабораторийн бичиг, баримттай байна. 2. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу сүүг зориулалтын саванд тээвэрлэн хүргэж ирнэ. 3. Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, гэрчилгээ, холбоо барих утасны дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. 4. Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь эх орны сүүн бүтээгдэхүүн байна. Барааны нэр: Шингэн сүү 1.Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан шинэ байна. 2.Гадны үнэр амт байхгүй, тослог 3,2- оос дээш тослогтой, шинэ, шингэн болон хөлдөөсөн байна. 3.Тээвэрлэлтийн горимыг чанд сахисан байх. 4.Итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт улирал бүр гаргасан байх Барааны нэр: Аарц, Монгол аргаар бэлтгэгдсэн шинэ. /хог хаягдал, шавьж хорхойгүй/ Цагаан өнгөтэй. Хэт исгэлүүн, ахарсан, хөгцөрсөн биш, хэт амтгүй биш, өтгөн монгол аргаар хийгдсэн байна.
2	Аарц	307	кг	
3	Ааруул	200	кг	
4	Өрөм	100	кг	
5	Эзэгий	100	кг	
6	Тараг	1000	л	
Багц 3: Хүнсний ногоо				
1	Хүрэн манжин	100	кг	1.Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж өгнө. Дагалдах баримт бичигт жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, гэрчилгээний хуулбар, холбоо барих утасны дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. 2.Төмс, хүнсний ногоо нь эх орны хөрсөнд ургасан. 3.Ялзарч муудаагүй шинэ, хадгалалт сайтай байна. 4.Тус тусдаа савлагдсан байна. Чулуу, шорооны хольцгүй байна
2	Төмс	1200	кг	
3	байцаа	1200	кг	
4	Манжин	300	кг	
5	Лууван	300	кг	
6	Сонгино	100	кг	
7	Сармис	50	ш	
Багц 4: Мах махан бүтээгдэхүүн				
1	Үхэр мах	1615	кг	1.Нийлүүлэгдэх мах нь стандартын шаардлага хангасан байна . 2.Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, гадаргуу цэвэр, гадны үнэр, амтгүй /шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон малын ялгадасгүй байх/ байна. 3. Үхэр, хонины мах, тахианы цээж мах байна. Хонины мах 1 гулууз нь 20кг-с дээш байх. 4.Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн, гарал үүслийн гэрчилгээ бүхий 1 дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна Мал эмнэлгийн гарал үүслийн бичигтэй байна
2	Хонь мах	530	кг	
3	Тахианы цээж мах	50	кг	
Багц 5: Бусад бүтээгдэхүүн				
1	Цай Их тайга	30	ш	1. Бүтээгдэхүүн тус бүр зориулалтын

				саванд савлагдсан.
2	Масло /50% тослогтой /	30	кг	<p>2. Хадгалах хугацаа дуусаагүй, шинэ, тээвэрлэлтийн явцад гэмтэж, муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна</p> <p>Барааны нэр-Цай. Их тайга болон түүнтэй дүйцэхүйц байна</p> <p>Барааны нэр- Масло, ургамлын тос, давс, сахар Орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.</p> <p>Барааны нэр- Давс, Зөгийн бал, чацаргана, нэрс, аньс, улаан лооль, өргөст хэмх Монгол улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.</p> <p>Барааны нэр- Далайн байцаа, чокопай Солонгос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.</p> <p>Барааны нэр- Варенье. Герман улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.</p> <p>Барааны нэр: цөцгийн тос сүү ХК-ний бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байна.</p> <p>Барааны нэр: Хоол амтлагч, шоколадны крем, молоко, чихэр, личо нь орос улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн болон түүнтэй дүйцэхүйц байна.</p>
3	Ургамлын тос	250	л	
4	Давс	50	кг	
5	Исгэгч	151	ш	
6	Сахар / 50 кг /	250	кг	
7	Зөгийн бал /250 гр /	20	ш	
8	Зөгийн бал том	20	ш	
9	Далайн байцаа	80	ш	
10	Варень /1 литр/	50	ш	
11	Алаг салат	30	ш	
12	Үзэм	50	кг	
13	Чацаргана	50	кг	
14	Аньс	50	кг	
15	Улаан лооль	30	ш	
16	Нэрс	50	кг	
17	Еэвэн	150	уут	
18	Боорцог	100	ш	
19	Чокопай /12 ширхэгтэй	50	хайрцаг	
20	Цөцгий тос /1кг/	50	ш	
21	Чихэр	10	кг	
22	Молоко /300гр/	20	ш	
23	Шоколадны крем /700 гр/	30	ш	
24	Хар чавга	20	кг	
25	Өргөст хэмх	20	кг	
26	Даршилсан өргөст хэмх /650 гр/	20	ш	
27	Личо	20	ш	
28	Хоол амтлагч /4-н төрөл/	20	ш	

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр төрөл	Тоо	Хэмжих нэгж	Инкотермийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
			Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1-р багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн					
Нэгдүгээр гурил 25 кг	500	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Хоёрдугаар гурил кг	100	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Цагаан будаа /25кг/	100	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

Гурвалжин будаа /650 гр/	40	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Шар будаа /650 гр/	80	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Овьёос	60	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Хүүхдийн будаа	60	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Гоймон / 3 кг /	6	кш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Хөц будаа	30	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Гоймон / 350 гр /	80	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

Шингэн сүү	300	л	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Аарц	300	л	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

3-р багц: Хүнсний ногоо

Хүрэн манжин	60	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Төмс	500	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Байцаа	300	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Манжин	120	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Лууван	120	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Сонгино	100	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Сармис	180	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

4-р багц: Мах, махан бүтээгдэхүүн

Үхэр мах	300	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Хонь мах	300	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

5-р багц: Бусад бүтээгдэхүүн

Цай	24	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Масло /50% тослогтой /	80	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Ургамлын тос	36	л	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Давс	12	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Исгэгч	100	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Сахар / 50 кг /	120	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Зөгийн бал /250 гр /	60	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Далайн байцаа	120	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Варень 500 гр	36	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Перец	10	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Үзэм	80	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

Чацаргана	60	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Чангааз	50	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Өндөг	400	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Хар чавга	60	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Чинжүү	60	кг	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	
Томат	24	ш	2020.03.09	2021 оны нийлүүлэгчийг шалгартал	

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг багц болгоноор тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэжбүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхайхийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН –2)
- Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримтбичгүүд:
- 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[моо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[моо]**
- Алдангийн нийт дүн: **[моо]**

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож

оны сарын-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны дугаар сарын _____-наас _____ оны дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарынүсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарынүсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

